



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 269

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 нэрийн нийт 62,748,462.00 (жаран хоёр сая долоон зуун дөчин найман мянга дөрвөн зуун жаран хоёр) төгрөгийн балансын үнэ, 61,665,650.00 (жаран нэгэн сая зургаан зуун жаран таван мянга зургаан зуун тавин) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасч Булган аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгөхийг зөвшөөрсүгэй.

2.Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бямбадагва, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Г.Ёндон, Булган аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Баттулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хавсралтад заасан хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд (Булган аймгийн Цагдаагийн газар)-д эзэмшүүлэх, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан тайлагнах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005366  
14-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн  
06 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭИ, ДАНСНААС  
ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д.д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
			(төгрөг)		
1	Фермер-УАЗ 39094 №30-83орх	12/31/2007	23,103,000.00	23,103,000.00	-
2	УАЗ-374102 груз.фургон №16-02ора	3/31/2007	21,000,000.00	21,000,000.00	-
3	Хьюндай старекс №46-88 оро	6/30/2019	18,645,462.00	17,562,650.00	1,082,812.00
Нийт дүн			<b>62,748,462.00</b> (жаран хоёр сая долоон зуун дөчин найман мянга дөрвөн зуун жаран хоёр)	<b>61,665,650.00</b> (жаран нэгэн сая зургаан зуун жаран таван мянга зургаан зуун тавин)	<b>1,082,812.00</b> (нэг сая наян хоёр мянга найман зуун арван хоёр)